



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын дөрөвдүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/087/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 70363040 Цахим хаяг: batmunkhb @audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 70363036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn Аудитын гүйцэтгэсэн: “Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбар Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com</p>
-------------------------------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

Г МАНДАЛ СУМЫН ДӨРӨВДҮГЭЭР Г  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Л.ГАНТӨМӨР ТАНАА

2026.02.25 № СЭА-2026/087/НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г **Хязгаарлалттай дүгнэлт** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын дөрөвдүгээр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас 935.4 мянган төгрөгийн урамшууллыг амралтын хугацаанд бодож олгосон,
- Төсөвт тусгагдаагүй 1,099.6 мянган төгрөгийн мэргэшлийн зэргийн нэмэгдлийг олгосон,
- Өндөр насны тэтгэврээ тогтоолгон, төрийн албанаас бүрмөсөн чөлөөлөгдөж, гэрээгээр ажиллаж буй ажилтанд төрийн алба хаасны 536.5 мянган төгрөгийн нэмэгдэл цалинг олгосон,

- Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлээгүй, сум, аймгийн түвшинд амжилт гаргасныг нотлох баримтгүйгээр 2,750.3 мянган төгрөгийн цалинг илүү бодож олгосон,
- Хүүхдийн хоолны 35,144.6 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй,

Аудитаар илэрсэн дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, ТБОНӨХБАУХА тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтууд болон Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 2, 5 дугаар хавсралтын 6, 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоолын хавсралтын 1, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 сарын 01-ний өдрийн А/35, А/102 дугаар хамтарсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтын 10 дахь заалтуудтай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Боловсролын ерөнхий газраас 2,771.0 мянган төгрөгийн компьютер, угаалгын машиныг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, Мандал сумын ИТХ-ын 2025 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор 6,744.5 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, ашиглалтын хугацаа дууссан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч дахин ашиглах боломжтой 22 нэр төрлийн 23,206.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасаж, ашиглах хугацааг сунгаж орлогод авсан байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус цэцэрлэг нь 2025 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 10 зорилтын хүрээнд 54 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 91.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Тод-руулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4	51,821,879.12	15,962,832.33
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		51,821,879.12	15,962,832.33
3121	Төгрөг		51,821,879.12	15,962,832.33
31211	Төрийн сангийн харилцах		51,821,879.12	15,962,832.33
33	АВЛАГА	5	5,000,000.00	
331	Ажиллагчидтай холбогдсон авлага		5,000,000.00	
35	БАРАА МАТЕРИАЛ	6	24,720,755.00	27,396,005.00
354	Хангамжийн материал		24,720,755.00	27,396,005.00
3541	Бичиг хэргийн материал		112,900.00	148,900.00
3542	Аж ахуйн материал		6,351,600.00	6,447,600.00
3545	Барилгын засварын материал		3,954,800.00	5,654,800.00
3546	Хүнсний материал		463,000.00	331,750.00
3547	Бусад хангамжийн материал		13,838,455.00	14,812,955.00
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		81,542,634.12	43,358,837.33
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	853,878,865.00	851,967,620.44
392	Биет хөрөнгө		821,353,864.82	819,567,620.24
39201	Барилга, байгууламж, орон сууц		930,000,000.00	930,000,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл		(149,833,333.70)	(165,333,333.74)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		59,192,400.00	55,218,960.00
39206	Хуримтлагдсан элэгдэл		(32,181,197.45)	(21,409,689.05)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		25,866,207.62	25,866,207.62
39208	Хуримтлагдсан элэгдэл		(19,913,735.06)	(19,244,399.46)
39214	Бусад үндсэн хөрөнгө		21,164,712.90	21,164,712.90
39215	Хуримтлагдсан элэгдэл		(12,941,189.49)	(6,694,838.03)
393	Биет бус хөрөнгө		32,525,000.18	32,400,000.20
39301	Програм хангамж		1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(1,124,999.82)	(1,249,999.80)
39303	Бусад биет бус хөрөнгө		32,400,000.00	32,400,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		853,878,865.00	851,967,620.44
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		935,421,499.12	895,326,457.77
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9	10,337,820.05	
413	Өглөг		10,337,820.05	
4131	Ажилчидтай холбогдсон өглөг		10,337,820.05	
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		10,337,820.05	
51	Засгийн газрын хувь оролцоо		925,083,679.07	895,326,457.77
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		32,400,000.00	32,400,000.00
512	Хуримтлагдсан үр дүн		892,683,679.07	862,926,457.77
5121	Өмнөх үеийн үр дүн		892,683,679.07	892,683,679.07
5122	Тайлант үеийн үр дүн			(29,757,221.30)
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		925,083,679.07	895,326,457.77
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		935,421,499.12	895,326,457.77

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Тод-руулга	Өмнөх он	Тайлант он
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		618,388,942.33	734,719,029.09
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		573,052,300.00	693,381,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		573,052,300.00	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих			693,381,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		45,336,642.33	41,337,429.09
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		45,336,642.33	41,337,429.09
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		14,498,249.00	25,977,747.50
120	Нийтлэг татварын бус орлого		14,498,249.00	25,977,747.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		5,000,000.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		5,000,000.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		9,498,249.00	25,977,747.50
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2	632,887,191.33	760,696,776.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ		640,982,780.35	790,453,997.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		635,287,961.35	789,514,997.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		458,997,401.96	606,070,049.74
210101	Үндсэн цалин		318,414,004.94	344,732,911.95
210102	Нэмэгдэл		126,919,147.02	223,060,117.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт			19,655,000.00
210104	Урамшуулал		13,664,250.00	18,622,020.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		58,636,742.18	71,626,477.00
210201	Тэтгэврийн даатгал		42,120,426.96	49,355,685.32
210202	Тэтгэмжийн даатгал		4,151,066.08	5,150,649.52
210203	ҮОМШӨ-ний даатгал		2,166,946.05	3,382,155.21
210204	Ажилгүйдлийн даатгал		1,994,164.30	5,054,558.01
210205	Эрүүл мэндийн даатгал		8,204,138.79	8,683,428.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		25,337,442.33	24,428,431.09
210301	Гэрэл, цахилгаан		5,721,252.33	8,393,711.09
210302	Түлш, халаалт		14,580,055.86	14,252,060.00
210303	Цэвэр, бохир ус		5,036,134.14	1,782,660.00
2105	Нормативт зардал		32,425,685.00	33,444,150.00
210502	Хоол, хүнс		32,425,685.00	33,444,150.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		16,979,200.00	15,208,998.00
210604	Урсгал засвар		16,979,200.00	15,208,998.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,413,100.00	526,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		2,125,100.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		288,000.00	526,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		40,498,389.88	38,210,892.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		10,702,400.00	6,686,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		3,636,800.00	3,635,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		26,159,189.88	27,888,992.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		5,694,819.00	939,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		5,694,819.00	939,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		5,694,819.00	939,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3	640,982,780.35	790,453,997.89
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		(8,095,589.02)	(29,757,221.30)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН			
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		380,395.65	
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал		380,395.65	
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		(380,395.65)	
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		(8,475,984.67)	(29,757,221.30)

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	623,388,942.33	734,719,029.09
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,000,000.00	
120	Нийтлэг татварын бус орлого	5,000,000.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,000,000.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	618,388,942.33	734,719,029.09
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	573,052,300.00	693,381,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	573,052,300.00	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		693,381,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,336,642.33	41,337,429.09
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,336,642.33	41,337,429.09
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	618,494,995.42	770,578,075.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	618,494,995.42	770,578,075.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	609,850,176.42	769,639,075.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	459,049,920.47	611,407,869.79
210101	Үндсэн цалин	318,466,523.45	349,986,519.00
210102	Нэмэгдэл	126,919,147.02	223,060,117.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт		19,655,000.00
210104	Урамшуулал	13,664,250.00	18,706,233.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,246,403.62	71,626,477.00
210201	Тэтгэврийн даатгал	36,730,088.40	49,355,685.32
210202	Тэтгэмжийн даатгал	4,151,066.08	5,581,649.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,166,946.05	2,951,156.21
210204	Ажилгүйдлийн даатгал	1,994,164.30	4,150,042.01
210205	Эрүүл мэндийн даатгал	8,204,138.79	9,587,943.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,337,442.33	24,428,431.09
210301	Гэрэл, цахилгаан	5,721,252.33	8,393,711.09
210302	Түлш, халаалт	14,580,055.86	14,252,060.00
210303	Цэвэр, бохир ус	5,036,134.14	1,782,660.00
2104	Хангамж, бараа материалын зардал	38,000.00	
210401	Бичиг хэрэг	38,000.00	
2105	Нормативт зардал	32,364,410.00	33,312,900.00
210502	Хоол, хүнс	32,364,410.00	33,312,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,999,200.00	16,908,998.00
210604	Урсгал засвар	19,999,200.00	16,908,998.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,413,100.00	526,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,050,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	363,100.00	526,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,401,700.00	11,428,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,466,600.00	7,916,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,935,100.00	3,511,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,644,819.00	939,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,694,819.00	939,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,694,819.00	939,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,950,000.00	
213304	Хөрөнгийн	2,950,000.00	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	4,893,946.91	(35,859,046.79)
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	4,893,946.91	(35,859,046.79)
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		51,821,879.12
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		15,962,832.33

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	32,400,000.00		892,683,679.07	925,083,679.07
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн			(29,757,221.30)	(29,757,221.30)
19	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	32,400,000.00		862,926,457.77	895,326,457.77

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	789,361,300.00	742,785,800.00	46,575,500.00	94.1
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	739,411,800.00	693,381,600.00	46,030,200.00	93.8
131001	Улсын төсвөөс санхүүжих	693,734,400.00	693,381,600.00	352,800.00	99.9
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	45,677,400.00	-		
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	49,949,500.00	49,404,200.00	545,300.00	98.9
132001	Орон нутгийн төсвөөс	49,949,500.00	49,404,200.00	545,300.00	98.9
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	789,361,300.00	742,785,800.00	46,575,500.00	94.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	789,361,300.00	770,578,075.88	18,783,224.12	97.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	788,420,700.00	769,639,075.88	18,781,624.12	97.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	613,819,700.00	611,407,869.79	2,411,830.21	99.6
210101	Үндсэн цалин	377,029,400.00	349,986,519.00	27,042,881.00	92.8
210102	Нэмэгдэл	221,021,000.00	223,060,117.40	(2,039,117.40)	100.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт		19,655,000.00	(19,655,000.00)	
210104	Урамшуулал	15,769,300.00	18,706,233.39	(2,936,933.39)	118.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,266,500.00	71,626,477.00	4,640,023.00	93.9
210201	Тэтгэврийн даатгал	51,713,700.00	49,355,685.32	2,358,014.68	95.4
210202	Тэтгэмжийн даатгал	6,138,200.00	5,581,649.52	556,550.48	90.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,069,100.00	2,951,156.21	117,943.79	96.2
210204	Ажилгүйдлийн даатгал	3,069,100.00	3,367,210.36	(298,110.36)	109.7
210205	Эрүүл мэндийн даатгал	12,276,400.00	10,370,775.59	1,905,624.41	84.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,035,500.00	24,428,431.09	8,607,068.91	
210301	Гэрэл, цахилгаан	11,487,500.00	8,393,711.09	3,093,788.91	
210302	Түлш, халаалт	15,000,000.00	14,252,060.00	747,940.00	
210303	Цэвэр, бохир ус	6,548,000.00	1,782,660.00	4,765,340.00	
2104	Хангамж, бараа материалын зардал				
2105	Нормативт зардал	35,144,600.00	33,312,900.00	1,831,700.00	94.8

210502	Хоол, хүнс	35,144,600.00	33,312,900.00	1,831,700.00	94.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,914,000.00	16,908,998.00	5,002.00	
210604	Урсгал засвар	16,914,000.00	16,908,998.00	5,002.00	
2107	Томилолт, зочны зардал				
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,717,800.00	526,000.00	1,191,800.00	30.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,717,800.00	526,000.00	1,191,800.00	30.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,522,600.00	11,428,400.00	94,200.00	99.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,010,900.00	7,916,700.00	94,200.00	98.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,511,700.00	3,511,700.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	940,600.00	939,000.00	1,600.00	99.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	940,600.00	939,000.00	1,600.00	99.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	940,600.00	939,000.00	1,600.00	99.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ				
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	789,361,300.00	770,578,075.88	18,783,224.12	97.6
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		51,821,879.12	(51,821,879.12)	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		15,962,832.33	(15,962,832.33)	
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО				
5	АЖИЛЛАГСДЫН ТОО				
24	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ				

## ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 33,790.3 мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 22 нэр төрлийн 24,456.6 мянган төгрөгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй,
- Үндсэн хөрөнгийн бүртгэлд 1,249.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг тавилга эд хогшлын дансанд, 7,815.8 мянган төгрөгийн тавилга болон тоног төхөөрөмжийг бусад үндсэн хөрөнгийн дансанд буруу ангилан бүртгэсэн,
- Үр дүнгийн тайланд 268.0 мянган төгрөгийн бараа үйлчилгээний бусад зардлыг бичиг хэргийн зардлаар тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга агуулга”-ийн 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой...”, УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн ХЗУ<sup>14</sup>-д “... байгууллага нь тухайн хөрөнгийг уг тайлангийн өдрөөр түүний одоогийн бодит үнэ цэнээр дахин үнэлэх хэрэгтэй ...”, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Ангилал” батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

<sup>1</sup> ХЗУ-Хэрэгжүүлэх заавар удирдамж

Аудитаар нийт **44,598.7** мянган төгрөгийн 7 зөрчил<sup>2</sup> илэрснээс 5,321.8 мянган төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт, 35,144.6 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 4,132.3 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **40,466.4** мянган төгрөгийн материаллаг залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 34,056.6 мянган төгрөгөөр давсан тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

### 3.1 Төлбөрийн акт

1. Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлээгүй, сум, аймгийн түвшинд амжилт гаргасныг нотлох баримтгүйгээр 6 багшид тус бүр 15.0-20.0 хувиар тооцон **2,750.3 мянган** төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”*, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 сарын 01-ний өдрийн А/35, А/102 дугаар хамтарсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтын 10 дахь *“Энэхүү баримт бичгийн 4,5-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлгээнд 60.0 ба түүнээс дээш хувь үнэлэгдсэн багш, ажилтны ажлын үр дүн, манлайлал, мэргэжлийн хөгжлийн ахиц дэвшил, амжилтын түвшнийг харгалзан нэмэгдлийг дараах хувиар тогтооно. “цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10 хувь”, “сумын түвшинд 15 хувь”, “аймгийн түвшинд 20 хувь”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Тооцооллын алдаанаас 3 багшид амралтын үед буюу 6 сард **935.4 мянган** төгрөгийн багшийн гүйцэтгэлийн үр дүнгийн урамшуулал бодож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3. Жижүүр Д.Ганбаярт цахилгаанчны мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 15 хувиар тооцож **1,099.6 мянган** төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”*, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтын 6 дахь *“Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдлийг зөвхөн тухайн мэргэжлээрээ ажиллаж байгаа хугацаанд нь олгоно.”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4. Тайлант онд өндөр насны тэтгэврээ тогтоолгон, төрийн албанаас бүрмөсөн чөлөөлөгдөж, гэрээгээр ажиллаж буй тогооч Б.Энх-амгаланд **536.5 мянган** төгрөгийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг олгосон. Энэ нь Төсвийн тухай

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын 2 дахь “Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн төрийн албан хаагчийн төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан түүний албан тушаалын сарын үндсэн цалингаас ... бодож олгоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Биет бус хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал:**

1.1 Илрүүлэлт: Биет бус хөрөнгийн бүртгэлд 32,400.0 мянган төгрөгийн 1800м2 хэмжээтэй 1 газар бүртгэлтэй байна. Үүнээс гадна Мандал сумын Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн А/175 дугаар захирамжаар 909 м2 газрыг тус цэцэрлэгт эзэмшүүлсэн боловч уг газрыг үнэлгээ хийлгээгүй, балансад тусгаагүй, мөн хувь иргэний нэр дээр давхцал үүссэн маргаантай байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна

Өгсөн зөвлөмж: Биет бус хөрөнгийг бүртгэл тайланд бүрэн, зөв дүнгээр тусгаж байх зөвлөмж хүргүүллээ.

#### **2. Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал:**

1.2 Илрүүлэлт: Эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй бэлтгэсэн 4,132.3 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, нягтлан бодох бүртгэлд тусгаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.5-д “бүх орлого” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд, санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалыг бүртгэл тайланд бүрэн, зөв дүнгээр тусгаж байх зөвлөмж хүргүүллээ.

Дээрх төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй	1	24,456.6	1	24,456.6			1	24,456.6				
Үндсэн хөрөнгийг буруу ангилан бүртгэсэн	1	9,065.0			1	9,065.0	1	9,065.0				
Үр дүнгийн тайланд зардал буруу тайлагнасан	1	268.0			1	268.0	1	268.0				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>33,790.3</b>	<b>1</b>	<b>24,456.6</b>	<b>2</b>	<b>9,333.7</b>	<b>3</b>	<b>33,790.3</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ур чадварын нэмэгдэл цалинг илүү бодож олгосон	1	2,750.3	1	2,750.3								
Тооцооллын алдаанаас амралттай үед багшийн гүйцэтгэлийн үр дүнгийн урамшуулал бодож олгосон	1	935.4	1	935.4								
Мэргэшлийн зэргийн нэмэгдлийг илүү бодож олгосон	1	1,099.6	1	1,099.6								
Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг илүү бодож олгосон	1	536.5	1	536.5								

Биет бус хөрөнгийг бүртгэлд зөв дүнгээр тусгаагүй	1	-					1	-				
Үнэ төлбөргүй орлогыг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй	1	4,132.3					1	4,132.3				
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>9,454.1</b>	<b>4</b>	<b>5,321.8</b>			<b>2</b>	<b>4,132.3</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон.	1	-						1	-
<b>Дүн</b>	<b>1</b>							<b>1</b>	
Бусад хууль тогтоомжийн хуулийн хэрэгжилттэй холбоотой									
Хүүхдийн хоолны худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулаагүй	1	35,144.6					1	35,144.6	
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>35,144.6</b>					<b>1</b>	<b>35,144.6</b>	
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>35,144.6</b>					<b>1</b>	<b>35,144.6</b>	<b>1</b>

### ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		